

МОНГОЛ УЛСЫН СТАНДАРТ

Ангилалтын код 59.020

Ноос, ноолуур. Савлах, хаяглах, хадгалах, тээвэрлэх. Техникийн шаардлага	MNS 215:2007 MNS 215:2001-ын оронд
Textiles. Packing, marking, storing, transporting of animal fibres. Technical requirement	

Стандартчилал, Хэмжилзүйн Үндэсний Зөвлөлийн 2007 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 61 дүгээр тогтоолоор батлав.

Энэ стандарт нь 2008 оны 02 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн хүчинтэй.

Энэ стандартын норматив шаардлагыг заавал мөрдөнө.

1. Хамрах хүрээ

Энэ стандарт нь бүх төрлийн малын гаралтай ширхэгт материалыг савлах, хаяглах, хадгалах, тээвэрлэх журмыг тогтооно.

2. Техникийн шаардлага

2.1 Бүх төрлийн ноос, ноолуур, ширхэгт материалыг хэрэглэгчтэй тохирсон гэрээний нөхцөлийн дагуу савлаж, хаяглаж, хадгалж, тээвэрлэнэ. Энэ нөхцөл нь олон улсын стандартын шаардлагад нийцэж байна.

2.2 Экспортод гаргах бүх төрлийн ноос, ноолуур, ширхэгт материалыг /90x700x480/ мм-ээс дээшгүй хэмжээтэй савлаж, зориулалтын даавуу болон таараар битүү ороож зориулалтын бүслүүрээр багласан байна.

2.3 Төрөл бүрийн ноос, ноолуур, ширхэгт материалыг өөр хооронд нь хольж савлахыг хориглоно.

2.4 Хаягийг баглааны хоёр булангийн аль нэг тал дээр /55x45/ см-ийн зайд үг үсэг, тоог тод харагдахаар гадны нөлөөнд арилахгүй будаг, бэхээр бичнэ.

2.5 Савласан төрөл бүрийн ноос, ноолуур, ширхэгт материалыг шалнаас дээш 15 см өндөрлөсөн тавиур дээр, хананаас 0,5 м-ийн дотогш зайд хурааж хадгална.

2.6 Баглааг ил задгай, бүтээлэг, суурьгүй агуулахад хадгалахыг хориглоно.

2.7 Багласан ноос, ноолуур, ширхэгт материалыг бүх төрлийн тээврийн хэрэгслээр бүтээлэгтэй тээвэрлэнэ.

2.8 Экспортод гаргахаар тээвэрлэж буй бүх төрлийн ноос, ноолуур, ширхэгт материалд мал эмнэлэг, ариун цэвэр, чанар, гарал үүслийн гэрчилгээ дагалдуулсан байна.

ТӨГСӨВ.